



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/87/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

(Хотын нэр оруулах)

2018 он

Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа

Утас: 7052-2734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.com

Аудитын менежер: Ц.Лүндэгмаа

Утас: 7052-3020 Цахим хаяг:

Аудитор: Б.Байгал

Утас: 99359854 Цахим хаяг: mnbaudithhk@gmail.com


Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	33
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	(Аудитын чиглэл)	
3.1.1	Илрүүлэлт:	
3.1.2	Эрсдэл:.....	
3.1.3	Өгсөн зөвлөмж:.....	
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	
3.2	(Аудитын чиглэл)	
3.2.1	Илрүүлэлт:	
3.2.2	Эрсдэл:.....	
3.2.3	Өгсөн зөвлөмж:.....	
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	

1 Аудитын гэрчилгээ

 ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР 44103 Дорноговь аймаг, Сайншанд сум, 3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр, Утас: (705) 2-27-34	ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙХАН ДУЛААН СУМЫН СОЁЛЫН ТӨВД
2019-02-19 № 1-6/87	
тантай _____ -ны № _____ -т	
Аудитын гэрчилгээ	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-т заасны дагуу Дорноговь аймгийн Сайхандулаан сумын соёлын төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p>	
Зөрчилгүй санал дүгнэлт	
<p>Дорноговь аймгийн Сайхандулаан сумын соёлын төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p>	
Санал дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p>	
<p>Аудитаар Дорноговь аймгийн Сайхандулаан сумын соёлын төвийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p>	
	

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн хуулийн 54.3, 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодож бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

ОРШИЛ

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Эрхлэгч Д.Дөлгөөнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.1 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.11-нээс 2019.02.18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.19-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газартай гэрээ байгуулсан “Мөнгөн Нөөц Баялаг Аудит” ХХК хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.02.11-ний өдрийн 04 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.2 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв нь Дорноговь аймгийн Сайхан дулаа сумын ард иргэдэд жүжиг, хөгжим, бусад урлагийн үйл ажиллагаа шуурхай хүргэх соён гэгээрүүлэх, номын сангийн үйл ажиллагааг улам өргөжүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сумын нийт хүн амд соёл урлагаар үйлчлэх

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль
- ИТХ-ийн тогтоолууд

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Өөрчлөлт одоогоор байхгүй байна.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.5 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 5 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 0

асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.6 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардлын 1* хувиар сонгов.

Нийт зардал-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Нийт зардал нь тайлант онд зарцуулсан санхүүжилтийн дүнгээр илэрхийлэгдсэн байх тул сууриар сонгох нь зүйтэй гэж үзсэнтэй холбоотой юм.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв 2018 оны *Нийт зардал* 60400.3 мянган төгрөг бөгөөд түүний 1 хувь болох 604.00 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь эрсдэлийн төвшинтэй холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.7 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 2 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	2,657.50	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	3	2,657.50	

2.8 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж бичсэн.

Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар Өөрийн үйл ажиллагааны авлагыг олж цуглуулахдаа бүрэн төвлөрүүлж байгаа эсэхэд хяналт тавихуйцаар зохион байгуулалт хийж ажилласан эсэхийг дахин нягтлан шалгах шаардлагатай.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 11 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 49299,9 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлд, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 50143.9 мянган төгрөг буюу 101,7 хувьтай байгаа нь Тайлант жилд 49299.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас өөрийн орлого 1000,0 мянган төгрөгийг нэмж 50143.9 сая төгрөг зарцуулснаас шалтгаалжээ.

Төвлөрүүлэх шилжүүлэг хийгдээгүй

2.10 Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.11 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.12 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 1 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

Илрүүлэлт

Худалдан авалт хийсэн ажил гүйлгээ бүрд Е баримт хавсаргаагүй, иргэнтэй хийсэн нүүрсний гэрээг дүгнэх, зах зээлийн үнийн судалгаа хийх, хурлаар хэлэлцсэн талаарх баримтыг хангалтгүй бүрдүүлсэн байна.

Энэ нь үнэн зөв байх, илчлэл тодруулга, иж бүрэн байх, батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хуулийн 13 дүгээр зүйл, Засгийн газрын 24 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2017.12.05 ны 347 тоот тушаалаар батлагдсан Өмчийн бүх хэлбэрийн ААН байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх зааврыг /НХМ-ТМ-5/ тус тус зөрчсөн байна.

Эрсдэл

Төсвийн хөрөнгийн үр ашиг буурах эрсдэлтэй

Зөвлөмж

Төсвийн данснаас зарцуулалт хийхдээ Засгийн газрын 24 дүгээр тогтоолоор баталсан Төрийн сангийн үйл ажиллагааны журмын 7.8-д заасан баримтыг бүрдүүлж байх

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын соёлын төвийн Эрхлэгч Д.Дөлгөөн нягтлан бодогч Э.Алтанчимэг

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 16-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.2 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт

Тайлант онд 12 сарын цалингаас нийт 1657,5 мянган төгрөгийн суутгал хийссэнээс 1065,0 мянган төгрөг нь хуримтлалд суутган Хаан банкны 5369052023 тоот Д.Ариунцэцэгийн данс руу хогны үнэ 3 ажилтнаас 18,0 мянган төгрөг, өвсний үнэ 63,6 мянган төгрөг, торгууль 510,9 мянган төгрөгийг тус тус суутгаж шилжүүлсэн байна Энэ нь үнэ зөв байх. эрх үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Хөдөлмөрийн тухай хуулийн “60.1.Ажилтны цалин хөлсийг сард хоёр ба түүнээс дээш удаа, тогтоосон өдөр олгоно, 63.1.Ажилтны цалин хөлснөөс зөвхөн дор дурдсан тохиолдолд суутгал хийж болно, 63.1.1.ажилтны нэг сарын дундаж цалин хөлснөөс хэтрэхгүй хэмжээний хохирлыг нөхөн төлүүлэх тухай ажил олгогчийн шийдвэр гарсан,63.1.2.хууль тогтоомжид заасан бусад тохиолдол.”заалтуудыг зөрчсөн байна.

Эрсдэл

Ажилчдын гарт олгох цалин хөлс буурах эрсдэлтэй

Зөвлөмж

Цалин хөлсийг Хөдөлмөрийн хуульд нийцүүлэн олгож байх, дотоод журамд энэ талаарх заалтыг нэмэх, хуримтлалтай холбоотой заалтыг дотоод журмаас хасаж ажилчдын хурлаар шийдвэрлэн хуримтлалыг бэлнээр хураан авч ил тод мэдээлэн зарцуулах талаар шийдвэрлэх.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайншанд сумын соёлын төвийн Эрхлэгч Д.Дөлгөөн нягтлан бодогч Э.Алтанчимэг

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 16-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

3.3 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүн

Илрүүлэлт

Урлаг, үзвэр, соёлын арга хэмжээнд үйлчлүүлэгчид олгож байгаа тасалбар нь дугаар, он сар өдөр, тамга, гарын үсэг байхгүй байгаа нь орлого бүрэн орсон эсэхэд хяналт тавих боломжгүй байна Мөн гаднаас ирсэн урлагийн арга хэмжээнээс олсон орлогыг бэлнээр хураан авах, гэрээ хийсэн баримт, нэхэмжлэл байхгүй байгаа нь тохирсон төлбөрөө төлсөн эсэхийг батлах боломжгүй байна.Энэ нь иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна тухайн байгууллагад Төсвийн тухай хуулийн “5.1.3.санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, 16.5.2.батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” заалтууд хэрэгжихгүй байгааг харуулж байна.

Эрсдэл

Орлого бүрэн төвлөрөхгүй байх эрсдэлтэй.

Зөвлөмж

Соёлын ордны орлого бүрдүүлэлтэд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг хянаж болохуйцаар зохион байгуулж ажиллах.

Хариуцах ажилтан

Дорноговь аймгийн Сайхандулаан сумын соёлын төвийн Эрхлэгч Д.Дөлгөөн нягтлан бодогч Э.Алтанчимэг

Төсвийн захирагчийн хариу

Хэрэгжүүлэх зөвлөмжийг тусгасан алдаа зөрчлийн асуудлын бүртгэлийг 2019 оны 02 дүгээр сарын 16-ны өдөр баталгаажуулж ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.АРИУНАА Огноо:

АУДИТЫН МЕНЕЖЕР Ц.ЛҮНДЭГМАА Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Б.БАЙГАЛ Огноо:

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

4.1 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>7,694,087.30</u>	<u>8,410,687.30</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	7,694,087.30	8,410,687.30
354	Хангамжийн материал	7,694,087.30	8,410,687.30
35410	Бичиг хэргийн материал	42,500.00	42,500.00
35420	Аж ахуйн материал	414,500.00	1,037,900.00
35440	Түлш, шатах тослох материал	2,218,201.30	2,311,401.30
35470	Бусад хангамжийн материал	5,018,886.00	5,018,886.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>132,455,981.41</u>	<u>408,493,963.20</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	132,455,981.41	408,493,963.20
392	Биет хөрөнгө	132,455,981.41	402,137,963.20
39201	Барилга, байгууламж, орон сууц	154,453,400.00	359,625,110.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	34,424,206.00	44,424,206.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-13,256,953.55	-17,540,369.33
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,002,632.00	16,002,632.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,440,279.19	-5,393,780.47
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	2,014,450.00	2,014,450.00
39217	Ном	2,005,715.00	3,005,715.00
393	Биет бус хөрөнгө	00.00	6,356,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	6,356,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>140,150,068.71</u>	<u>416,904,650.50</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>37,340.00</u>	<u>-101,935.40</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	37,340.00	-101,935.40
413	Өглөг	37,340.00	-101,935.40
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	-139,269.00
4136	Бусад өглөг	37,340.00	37,333.60
41361	Байгууллагад төлөх өглөг	37,340.00	37,333.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>140,112,728.71</u>	<u>417,006,585.90</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	140,112,728.71	417,006,585.90
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	82,387,951.46	88,743,951.46
51101	Өмч: - төрийн	82,387,951.46	88,743,951.46
512	Хуримтлагдсан үр дүн	26,148,808.92	242,492,954.94
51210	Өмнөх үеийн үр дүн	26,148,808.92	26,148,808.92
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	216,344,146.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	31,575,968.33	85,769,679.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>140,150,068.71</u>	<u>416,904,650.50</u>

4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	25,539,600.00	276,744,431.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	308,500.00	227,444,531.00
120	Нийтлэг татварын бус орлого	308,500.00	227,444,531.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	308,500.00	227,444,531.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	308,500.00	1,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	226,444,531.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	00.00	1,000,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	25,231,100.00	48,299,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	24,532,467.52	56,335,326.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	24,532,467.52	56,335,326.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,532,467.52	56,179,316.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,283,007.00	35,389,146.00
210101	Үндсэн цалин	14,283,007.00	35,389,146.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,597,531.00	4,083,437.00
210201	Тэтгэврийн даатгал	1,597,531.00	2,664,957.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	238,410.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	370,619.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	132,210.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	677,241.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	2,959,421.00	6,753,650.00
210301	Гэрэл, цахилгаан	1,051,021.00	2,477,900.00
210302	Түлш, халаалт	1,908,400.00	4,111,950.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	163,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	347,315.00	1,011,343.60
210401	Бичиг хэрэг	115,800.00	249,700.00
210402	Тээвэр, шатахуун	10,150.00	418,643.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,615.00	65,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	188,750.00	157,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	358,600.00
210604	Урсгал засвар	00.00	358,600.00
2107	Томилолт, зочны зардал	14,000.00	62,000.00
210702	Дотоод албан томилолт	14,000.00	62,000.00

Сайхандулаан сум соёлын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	105,700.00	710,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,200.00	650,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	92,500.00	60,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,225,493.52	7,811,140.38
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	5,225,493.52	7,811,140.38
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	156,010.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	156,010.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	156,010.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,007,132.48</u>	<u>220,409,104.02</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	4,145,120.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	4,145,120.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-4,145,120.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,007,132.48</u>	<u>216,263,984.02</u>

4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	25,539,600.00	50,299,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	308,500.00	1,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	308,500.00	1,000,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	308,500.00	1,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	308,500.00	1,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,231,100.00	49,299,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	25,231,100.00	48,299,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	00.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	17,915,034.00	50,299,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,915,034.00	50,299,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,915,034.00	50,143,890.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,439,067.00	35,488,100.00
210101	Үндсэн цалин	13,438,095.00	32,516,400.00
210102	Нэмэгдэл	00.00	250,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,000,972.00	2,721,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,597,531.00	4,074,500.00
210201	Тэтгэврийн даатгал	1,597,531.00	2,716,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	271,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	339,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	67,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	679,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,243,271.00	6,836,700.00
210301	Гэрэл, цахилгаан	1,051,021.00	2,477,900.00
210302	Түлш, халаалт	170,000.00	4,195,000.00
210303	Цэвэр, бохир ус	22,250.00	163,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	64,465.00	1,598,290.00
210401	Бичиг хэрэг	8,900.00	149,000.00
210402	Тээвэр, шатахуун	10,150.00	78,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,615.00	65,100.00
210404	Ном, хэвлэл	12,800.00	1,062,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	122,590.00
2105	Нормативт зардал	00.00	46,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	46,900.00

Сайхандулаан сум соёлын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	00.00	1,008,400.00
210604	Урсгал засвар	00.00	1,008,400.00
2107	Томилолт, зочны зардал	14,000.00	62,000.00
210702	Дотоод албан томилолт	14,000.00	62,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	556,700.00	1,029,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	464,200.00	969,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	92,500.00	60,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00.00	156,010.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	156,010.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	156,010.00

4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	82,387,951.46	31,575,968.33	34,459,075.93	148,422,995.72
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	82,387,951.46	31,575,968.33	34,459,075.93	148,422,995.72
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,007,132.48	1,007,132.48
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	82,387,951.46	31,575,968.33	26,148,808.92	140,112,728.71
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	82,387,951.46	31,575,968.33	26,148,808.92	140,112,728.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	82,387,951.46	31,575,968.33	26,148,808.92	140,112,728.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	54,193,711.17	00.00	54,193,711.17
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	6,356,000.00	00.00	216,344,146.02	222,700,146.02
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	88,743,951.46	85,769,679.50	242,492,954.94	417,006,585.90

Сайхандулаан сум соёлын төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	49,299,900.00	50,143,890.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	49,299,900.00	50,143,890.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	49,299,900.00	50,143,890.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,488,100.00	35,488,100.00
210101	Үндсэн цалин	32,516,400.00	32,516,400.00
210102	Нэмэгдэл	00.00	250,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	2,971,700.00	2,721,700.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,152,400.00	4,074,500.00
210201	Тэтгэврийн даатгал	2,794,200.00	2,716,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	271,600.00	271,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	339,500.00	339,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	67,900.00	67,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	679,200.00	679,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,836,700.00	6,836,700.00
210301	Гэрэл, цахилгаан	1,985,900.00	2,477,900.00
210302	Түлш, халаалт	4,687,000.00	4,195,000.00
210303	Цэвэр, бохир ус	163,800.00	163,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	611,000.00	1,598,290.00
210401	Бичиг хэрэг	149,000.00	149,000.00
210402	Тээвэр, шатахуун	79,700.00	78,800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	65,100.00	65,100.00
210404	Ном, хэвлэл	62,800.00	1,062,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	132,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	122,400.00	122,590.00
2105	Нормативт зардал	46,900.00	46,900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	46,900.00	46,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,008,400.00	1,008,400.00
210604	Урсгал засвар	1,008,400.00	1,008,400.00
2107	Томилолт, зочны зардал	96,400.00	62,000.00
210702	Дотоод албан томилолт	96,400.00	62,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,060,000.00	1,029,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,000,000.00	969,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	60,000.00	60,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	49,299,900.00	50,299,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,299,900.00	48,299,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	49,299,900.00	48,299,900.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	1,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,000,000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	1,020.00	58,301.00
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00
620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00